



## НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**“НАМ, НЭР ДЭВШИГЧИЙН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН САНХҮҮЖИЛТ, ТҮҮНИЙ ГҮЙЦЭТГЭЛД ДҮГНЭЛТ ГАРГАХ, НИЙТЭД МЭДЭЭЛЭХ”**

Аудитын код: ГНАГ-2024/12-ШТА-НА-ДГА

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Дорноговь аймаг 2024 оны 12 сар</p>	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий	Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn
	Утас: 70522734	У.Оюунтүлхүүр
	Аудитын менежер:	Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn
	Утас: 70523020	Н.Мөнхнасан
	Аудитор:	Цахим хаяг: <a href="mailto:MunkhnasanN@audit.gov.mn">MunkhnasanN@audit.gov.mn</a>
		А.Дамчой
		Цахим хаяг: damchoia@audit.gov.mn

## АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт .....	2
Хүснэгтийн товъёг .....	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй .....	4-5
Үндсэн мэдээлэл .....	6
<b>БҮЛЭГ 1. ЗАРИМ НЭР ДЭВШИГЧИД ХУУЛЬД ЗААСАН ШААРДЛАГЫГ БАРИМТЛАЛГҮЙГЭЭР МӨНГӨН БОЛОН МӨНГӨН БУС ХАНДИВЫГ БҮРДҮҮЛСЭН БАЙНА.</b>	
<b>1.1 Нам болон нэр дэвшигч нар нь мөнгөн хандив хүлээн авахдаа банкны гүйлгээнд мэдээллээ бүрэн тусгаагүй байхад зарцуулах хөрөнгийн санхүүжилтийг бүрдүүлсэн байна .....</b>	<b>7-9</b>
1.1.1. Аймаг, сумын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуульд оролцож, сонгуулийн зардлын тайлангаа хуулийн хугацаанд иж бүрэн ирүүлсэн 3 нам 85,145.0 мянган төгрөг, 640 нэр дэвшигч 184,427.9 мянган төгрөгийн хуульд нийцсэн орлогыг сонгуулийн зардлын дансанд төвлөрүүлжээ .....	7-8
1.1.2. Нам, нэр дэвшигчид хуулиар зөвшөөрөгдөөгүй 26.0 сая төгрөгийн хандивыг буцаан шилжүүлээгүй, сонгуулийн үйл ажиллагаанд зарцуулсан байна .....	8-9
<b>1.2 Нам, нэр дэвшигч нь хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, зардлын дээд хэмжээг баримтлан ажилласан байна.....</b>	<b>10-13</b>
1.2.1 Хөрөнгийг хуульд заасан зориулалтын дагуу зарцуулсан байна .....	10
1.2.2 Аймаг, сумын ИТХ-ын ээлжит сонгуульд оролцсон, нэр дэвшигч нар анхан шатны баримтгүй, иргэдтэй байгуулсан гэрээний дагуу олгосон урамшууллаас холбогдох татварыг суутгаж, шилжүүлээгүй байна .....	10-13
1.2.3 Төрийн аудитын газраас тогтоосон зардлын дээд хэмжээг баримталж ажиллажээ .....	13
Дүгнэлт .....	14

### Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон Улсын стандарт
АНСДИТХСТ	Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай
АСХ	Аймгийн сонгуулийн хороо
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТАГ	Төрийн Аудитын газар
УБХ	Улсын бүртгэлийн хэлтэс
ААН	Аж Ахуй нэгж
ХАОАТ	Хүн амын орлогын албан татвар

### Хүснэгтийн товъёог:

Утга	Тайлбар
Хүснэгт 1	Аймаг, сумын ИТХ-ын ээлжит сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, нэр дэвшигчийн тоо
Хүснэгт 2	Намын сонгуулийн дансны орлого
Хүснэгт 3	Нэр дэвшигчийн сонгуулийн дансны орлого
Хүснэгт 4	Нэр дэвшигчтэй байгуулсан мөнгөн бус хандивын гэрээ, гэрээнд тусгасан үнэлгээ
Хүснэгт 5	Хандивлагчийн нэр, бүртгэлийн дугаар, эх үүсвэр тодорхойгүй хандивын зарцуулалт
Хүснэгт 6	Намын сонгуулийн зардлын ангилал
Хүснэгт 7	Нэр дэвшигчийн сонгуулийн зардлын ангилал
Хүснэгт 8	Анхан шатны баримтгүй зарцуулсан зардлын хэмжээ
Хүснэгт 9	Нам, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын хэмжээ

### Хавсралтын товъёог:

Утга	Тайлбар
Хавсралт 1	Аймаг, сумын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон намын сонгуулийн зардлын санхүүжилт
Хавсралт 2	Аймаг, сумын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон намын зардлын гүйцэтгэл
Хавсралт 3	Аймаг, сумын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын санхүүжилт
Хавсралт 4	Аймаг, сумын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын гүйцэтгэл
Хавсралт 5	Иргэдээс намд өгсөн банкны баримтад мэдээллээ бүрэн тусгаагүй хандивын дүн
Хавсралт 6	Намын буцаан шилжүүлээгүй хандивын жагсаалт
Хавсралт 7	Буцаан шилжүүлээгүй, зарцуулсан хандивын жагсаалт Ардчилсан намаас нэр дэвшигчид
Хавсралт 8	Буцаан шилжүүлээгүй, зарцуулсан хандивын жагсаалт Монгол ардын намаас нэр дэвшигчид
Хавсралт 9	Буцаан шилжүүлээгүй, зарцуулсан хандивын жагсаалт Иргэний хөдөлгөөн намаас нэр дэвшигчид
Хавсралт 10	Шадар туслах ухуулагч нарт олгосон урамшууллаас ХАОАТ суутгаагүй нэр дэвшигчийн жагсаалт
Хавсралт 11	Анхан шатны баримтгүй зарцуулалт хийсэн нэр дэвшигчид түүний жагсаалт
Хавсралт 12	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчдэд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийн жагсаалт

## Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд АНСДИТХСТ хуулийн 57 дугаар зүйлийг үндэслэн “Нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын санхүүжилт, түүний зарцуулалт, гүйцэтгэл”-д аудит хийж дүгнэлт гаргасан.</p> <p>Дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн А/37 дүгээр тушаалаар “Аймаг, сумын ИТХ-ын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам”-ыг баталсан.</p>
Аудитын зорилго, зорилт	<p>Нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын санхүүжилт, түүний зарцуулалтын тайланг хянаж, дүгнэлт гаргах, нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлэхэд оршино.</p> <p>Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд хийж гүйцэтгэсэн.Үүнд:</p> <p>Нам эвсэл, нэр дэвшигч нь сонгуульд зарцуулах хөрөнгийн санхүүжилтийг хуулийн дагуу бүрдүүлсэн эсэх</p> <p>Хөрөнгийг хууль, журамд заасны дагуу зарцуулсан эсэх.</p>
Аудитын хамрах хүрээ	<p>Аудитад аймаг, сумын ИТХ-ын ээлжит сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийг хамрууллаа.</p>
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	<p>Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, АДБОУС 400, АДБОУС 4000 дугаар стандартууд, Монгол Улсын Төрийн аудитын стандарт Нийцлийн аудит MNS 6817-6:2020, МУЕА-ын 2016 оны А/146 тушаалаар батлагдсан “Нийцлийн аудитын түр журам”-ыг баримтлан сонгуулийн зардлын тайлангийн талаар нам, нэр дэвшигч, ХАК-ний холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, ХАК-ний гаргасан дүгнэлтийн мэдээллийг нэгтгэх, хандив өгсөн иргэн, аж ахуйн нэгжийн талаарх тодруулгыг УБХ-ээс авах, тайлан, судалгаа, баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийн аудитын судалгаа, хөтөлбөр, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж дүгнэлт боловсруулж, нийтэд мэдээллээ.</p> <p>Дараах хууль эрх зүйн актыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:</p> <p>Төрийн аудитын тухай хууль, АНСДИТХСТ хууль,</p> <p>Дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны А/28 дүгээр тушаал Дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны А/31 дүгээр тушаал Дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны А/37 дүгээр тушаал Дээрх хуулиудтай нийцүүлэн гаргасан тогтоол, журам.</p>

<p>Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа</p>	<p>Аудитыг байгууллагын дарга, тэргүүлэх аудитор Т.Ган-Өлзий удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер У.Оюунтүлхүүр хэрэгжүүлэн, аудитор Н.Мөнхнасан А.Дамчой нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэсэн.</p> <p>Аудитын төлөвлөлтийн үе шатны ажлыг 2024 оны 11 дүгээр сарын 07-ны өдрөөс 11 дүгээр сарын 12-ны өдрийн хооронд гүйцэтгэж дуусгасан.</p> <p>Аудитын гүйцэтгэлийн үе шатны ажлыг 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрөөс эхлүүлж, тайлан болон дүнг 2024 оны 12 дугаар сарын 11-ны өдрөөр дуусган хандив өгсөн иргэн, хуулийн этгээдийн нийтэд мэдээллээ.</p>
---	--

## ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ:

Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн 68 тойрогт аймагт 5 намын 84 нэр дэвшигч, 14 суманд 3 намын 556 нэр дэвшигч, дэвшсэн байна.

Хүснэгт №1

Д/д	Нам эвсэл бие даагчийн нэрс	Нам	Аймагт нэр дэвшигч	Суманд нэр дэвшигч
1	Монгол ардын нам	1	35	274
2	Ардчилсан нам	1	35	260
3	Хүн нам	1	10	
4	Иргэний хөдөлгөөн нам	1	3	22
5	Үнэн ба зөв нам	1	1	
	<b>ДҮН</b>	<b>5</b>	<b>84</b>	<b>556</b>

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2-т “Нам, эвсэл болон нэр дэвшигчийг сонгуульд оролцуулахаар бүртгэх тухай шийдвэр гарснаас хойш энэ хууль болон банкны хууль тогтоомжид нийцүүлэн сонгуулийн зардлын дансыг нээлгэнэ.” гэж заасан. Орон нутгийн сонгуульд оролцсон 5 намаас Үнэн ба зөв нам болон Иргэний хөдөлгөөн нам зардлын данс нээлгээгүй байна.

АНСДИТХСТ хуулийн 56 дугаар зүйлийн 56.3-т “Нам, эвсэл нь санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ” гэж заасны дагуу сонгуулийн зардлын тайлангаа аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан төрийн аудитын байгууллагад хугацаандаа 3 нам, 640 нэр дэвшигч зардлын тайлан ирүүлсэн.

Аймаг, сумын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон нам болон нэр дэвшигч нарын зардлын тайланд хувийн аудитын 6 хуулийн эдгээд дүгнэлт гаргасан байна.

**БҮЛЭГ 1.НАМ БОЛОН НЭР ДЭВШИГЧИД НЬ СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН САНХҮҮЖИЛТИЙГ ХУУЛИЙН ДАГУУ БҮРДҮҮЛЖ, ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГААС ТОГТООСОН ЗАРДЛЫН ДЭЭД ХЭМЖЭЭНД ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛСАН БАЙНА.**

**1.1. Сонгуульд оролцогч нам, нэр дэвшигчид хуульд нийцэхгүй нийт 25,182.5 мянган төгрөгийн хандив бүрдүүлж, зарцуулсан байна.**

**1.1.1. Аймаг, сумын ээлжит сонгуульд оролцогч намууд нийт 85,145.0 мянган төгрөг, нэр дэвшигч нар 184,427.9 мянган төгрөгийн хандивыг хуулийн дагуу бүрдүүлсэн байна.**

Аймаг, сумын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуульд оролцож, сонгуулийн зардлын тайлангаа хуулийн хугацаанд ирүүлсэн 3 нам нийт 85,145.0 мянган төгрөг, 640 нэр дэвшигч 184,427.9 мянган төгрөгийн орлогыг сонгуулийн зардлын дансанд бүрдүүлж зарцуулсан байна.

*Намын сонгуулийн дансны орлого*

*Хүснэгт №2*

*/мянган төгрөг/*

№	Намын нэр	Орлогын ангилал								Нийт мөнгөн дүн
		Мөнгөн хандив						Мөнгөн бус хандив		
		Нам эвслийн өөрийн хөрөнгө		Хуулийн этгээд		Иргэн				
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн			
1	Монгол ардын нам	-	-	-	-	45	44,095.0	-	-	44,095.0
2	Ардчилсан нам	-	-	2	20,000.0	-	-	-	-	20,000.0
3	Хүн нам	-	-	1	5,000.0	1	200.0	-	-	5,200.0
4	Иргэний хөдөлгөөн нам	-	-	-	-	-	-	-	-	-
5	Үнэн ба зөв нам	-	-	-	-	-	-	-	-	-
6	Ардчилсан нам Замын-Үүд сум	1	14,850.0	-	-	-	-	-	-	14,850.0
7	Ардчилсан нам Сайхандулаан сум	-	-	-	-	1	1,000.0	-	-	1,000.0
<b>Нийт</b>		<b>1</b>	<b>14,850.0</b>	<b>3</b>	<b>25,000.0</b>	<b>47</b>	<b>45,295.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>85,145.0</b>

### Нэр дэвшигчийн сонгуулийн дансны орлого

Хүснэгт №3

/мянган төгрөг/

№	Намын нэр	Хандивын төрөл								Нийт мөнгөн дүн
		Мөнгөн хандив						Мөнгөн бус хандив		
		Нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө		Хуулийн этгээд		Иргэн				
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн			
1	Монгол ардын нам	176	36,749.0	6	5,500.5	257	84,193.7	-	-	126,443.2
2	Ардчилсан нам	137	3,247.9	1	5,000.0	179	31,587.9	-	-	39,835.8
3	Хүн нам	8	9.3	-	-	48	15,639.2	-	-	15,648.5
4	Иргэний хөдөлгөөн нам	10	10.4	-	-	10	2,490.0	-	-	2,500.4
5	Үнэн ба зөв нам	-	-	-	-	-	-	-	-	-
<b>Нийт</b>		<b>331</b>	<b>40,016.6</b>	<b>7</b>	<b>10,500.5</b>	<b>494</b>	<b>133,910.8</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>184,427.9</b>

АНСДИТХСТ хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т “Мөнгөн бус хандив өгч байгаа тохиолдолд хандивлагч нь нэр дэвшигч, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй хандивын гэрээг бичгээр байгуулж гэрээнд заасан зориулалтын дагуу зарцуулна”, 54.4-т “Мөнгөн бус хандивын үнэлгээг зах зээлийн дундаж ханшийг үндэслэн хандивын гэрээгээр тогтоох бөгөөд уг үнэлгээ нь иргэн болон хуулийн этгээдээс өгөх хандивын дээд хэмжээнээс хэтрэхгүй байна” гэж тус тус заасан.

Аймаг, сумын сонгуульд оролцогч 640 нэр дэвшигчээс 59 нэр дэвшигч нь хуулийн дагуу мөнгөн бус хандивын 260 гэрээг байгуулсан ч хууль, журамд заасны дагуу үнэлгээ тогтоогоогүй байна. Мөн 9 нэр дэвшигч мөнгөн бус хандив авсан ч хуулийн дагуу гэрээ байгуулж ажиллаагүй байна.

#### Нэр дэвшигчтэй байгуулсан мөнгөн бус хандивын гэрээ, гэрээнд тусгасан үнэлгээ

Хүснэгт №4

№	Хандивын төрөл	Мөнгөн бус хандив өгсөн иргэний тоо	Үнэлгээ тогтоосон мөнгөн бус хандивын гэрээ		Үнэлгээ тогтоогоогүй мөнгөн бус хандивын гэрээ		Гэрээ байгуулаагүй
			Тоо	Дүн, мянган төгрөг	Тоо	Дүн, мянган төгрөг	
1	Мөнгөн бус хандив	269	-	-	260	-	9

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсэгт “Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ.” гэж заасан.

Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчдэд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн 70 иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн 4 хуулийн этгээд байна. Хандив өгсөн иргэд, хуулийн этгээдийн жагсаалтыг хавсралтаар тусгасан.

**1.1.2 Нам, нэр дэвшигчид хуулиар зөвшөөрөгдөөгүй 25,182.5 мянган төгрөгийн хандивыг буцаан шилжүүлээгүй, сонгуулийн үйл ажиллагаанд зарцуулсан байна.**

АНСДИТХСТ хуулийн 53 дугаар зүйлийн 53.4-т “Хандив өгч байгаа иргэн, хуулийн этгээд нь нэр, иргэний бүртгэлийн дугаар болон хандивын эх үүсвэрийн талаарх мэдээллээ банкны гүйлгээний баримтад тусгах бөгөөд энэ шаардлагыг хангаагүй хандивыг хандив хүлээн авагч буцаан шилжүүлнэ”, 53.5-д “Буцах хаяг нь тодорхойгүй хандивыг холбогдох хууль тогтоомжийн дагуу улсын орлогод буюу төрийн санд шилжүүлнэ” гэж тус тус заасан.

Аймаг, сумын ИТХ-ын сонгуульд оролцсон нам болон нэр дэвшигчдэд мөнгөн хандив өгсөн иргэд, хуулийн этгээдээс банкны гүйлгээний баримтад мэдээллээ бүрэн тусгасан 541 иргэн, 10 хуулийн этгээд байна. Хуульд заасны дагуу овог нэр, бүртгэлийн дугаар, хандивын эх үүсвэрийг бүрэн тусгаагүй 373 иргэн, 3 хуулийн этгээд байснаас 242 иргэний 35,338.0 мянган төгрөгийг буцаан шилжүүлсэн байна.

Харин 131 иргэн 3 хуулийн этгээдийн нийт 25,182.5 мянган төгрөгийн хандивыг буцаан шилжүүлээгүй, сонгуулийн үйл ажиллагаанд зарцуулсан нь АНСДИТХСТ хуулийн 53 дугаар зүйлийн 53.4 дэх заалтыг зөрчсөн байна.

*Хандивлагчийн нэр, бүртгэлийн дугаар, эх үүсвэр тодорхойгүй хандивын зарцуулалт*

Хүснэгт №5

№	Нам, нэр дэвшигч	Иргэн		Хуулийн этгээд	
		Тоо	Хандивын дүн	Тоо	Хандивын дүн
1	Ардчилсан нам /Сайхандулаан сум /	1	1,000.0	-	-
2	Хүн нам	1	200.0	-	-
3	Монгол ардын нам /нэр дэвшигч/	49	7,478.6	3	4,000.0
4	Ардчилсан нам /нэр дэвшигч/	73	11,163.9	-	-
5	Иргэний хөдөлгөөн /нэр дэвшигч/	7	1,340.0	-	-
	<b>Дүн</b>	<b>131</b>	<b>21,182.5</b>	<b>3</b>	<b>4,000.0</b>

АНСДИТХСТ хуулийн 55 дугаар зүйлийн 55.1-д хандив өгөхийг хориглосон этгээдийг заасан ба уг шалгуурын дагуу хандив өгсөн хуулийн этгээд, иргэний жагсаалтыг аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт албан бичгээр хүргүүлэн шаардлага хангасан эсэхийг хариу бичгээр авсан.

Аудитад хамрагдсан нам, нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланд хуулиар хандив өгөхийг хориглосон хуулийн этгээдээс шилжүүлсэн хандив бүртгэгдээгүй байна.

Нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланд хийсэн хувийн аудитын компанийн дүгнэлтэд хуулийн шаардлага хангаагүй мөнгөн хандив болон мөнгөн бус хандивыг үнэн зөв тусгаагүй, хуульд нийцсэн гэж дүгнэсэн байна.

Хуульд заасны дагуу банкны гүйлгээнд мэдээлэл бүрэн тусгаагүй нийт 25,182.5 мянган төгрөгийн хандивыг хүлээн авч зарцуулсан нам болон нэр дэвшигч нарт холбогдох арга хэмжээ авч ажиллах саналыг аймгийн Татварын хэлтэс-д хүргүүлэв.

Мөн дээрх зөрчил нь Зөрчлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.21 дэх заалтыг зөрчсөн байна.

## 1.2 НАМ, НЭР ДЭВШИГЧ НЬ ХӨРӨНГИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛЖ, ЗАРДЛЫН ДЭЭД ХЭМЖЭЭГ БАРИМТЛАН АЖИЛЛАСАН БАЙНА.

### 1.2.1 Хөрөнгийг хуульд заасан зориулалтын дагуу зарцуулсан байна.

Сонгуулийн сурталчилгааны зардлыг хуульд заасны дагуу бэлэн бусаар зарцуулжээ. АНСДИТХСТ хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1-д “Нам, эвсэл болон нэр дэвшигчийг сонгуульд оролцуулахаар бүртгэсэн өдрөөс эхэлж, сонгуулийн зардлын тайлан гаргах өдрийг дуусах хүртэл хугацаанд энэ хуулийн 38.2-т заасан арга хэлбэрээр сонгуулийн сурталчилгаа явуулах зориулалтаар сонгуулийн зардлын данснаас дансанд шилжүүлэх хэлбэрээр зарлага гаргаж болно” гэж заасан.

Дээрх заалтын дагуу хуулийн 38.2-т заасан буюу сонгуулийн сурталчилгаанд зарцуулсан хөрөнгийг зөвхөн данснаас дансанд шилжүүлэх хэлбэрээр зарцуулсан байна.

Аймаг, сумын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуульд намууд сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх зардал 58,321.0 мянган төгрөг, нийтийн эзэмшлийн гудамж талбайд сурталчилгааны зурагт самбар байршуулах зардал 4,000.0 мянган төгрөг, ухуулах байрны түрээсийн зардал 11,349.4 мянган төгрөг, радио телевиз ашиглах зардал 10,880.0 мянган төгрөг, бусад зардал 566.5 мянган төгрөг, нийт 85,117.1 мянган төгрөг зарцуулжээ.

### Намын сонгуулийн зардлын ангилал

#### Хүснэгт №6

№	Намын нэр	Нийт зарлагын дүн	Зардлын ангилал				
			Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх зардал	Нийтийн эзэмшлийн гудамж талбайд сурталчилгааны зурагт самбар байршуулах зардал	Ухуулах байрны түрээсийн зардал	Сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах зардал	Бусад зардал /10%/
1	Дорноговь аймгийн Монгол Ардын намын хороо	44,095.0	30,000.0	4,000.0	-	10,000.0	95.0
2	Дорноговь аймаг дахь Ардчилсан нам	20,000.0	19,755.0	-	-	-	245.0
3	Замын-Үүд сум дахь Ардчилсан нам	14,850.0	4,837.3	-	9,999.4	-	13.4
4	Сайхандулаан сум дахь Ардчилсан нам	1,000.0	-	-	800.0	-	200.0

5	Дорноговь аймаг дахь Хүн нам	5,172.1	3,729.0	-	550.0	880.0	13.1
6	Дорноговь аймаг дахь Иргэний хөдөлгөөн нам	-	-	-	-	-	-
7	Дорноговь аймаг дахь Үнэн ба зөв нам	-	-	-	-	-	-
<b>Нийт дүн</b>		<b>85,117.1</b>	<b>58,321.3</b>	<b>4,000.0</b>	<b>11,349.4</b>	<b>10,880.0</b>	<b>566.5</b>

Монгол ардын намаас нэр дэвшигчид 123,886.0 мянган төгрөг, Ардчилсан намаас нэр дэвшигчид 37,022.3 мянган төгрөг, Хүн намаас нэр дэвшигчид 21,147.8 мянган төгрөг, Иргэний хөдөлгөөн намаас нэр дэвшигчид 2,362.0 мянган төгрөг, нийт 184,418.0 мянган төгрөгийг сонгуулийн зардлын данснаас хуулийн дагуу зарцуулсан байна.

### *Нэр дэвшигчийн сонгуулийн зардлын ангилал*

*Хүснэгт №7*

№	Зардлын ангилал	Дүн, мянган төгрөг
<b>Монгол ардын нам</b>		
1	Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх зардал	2,236.0
2	Нийтийн эзэмшлийн гудамж талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар байршуулах зардал	7,681.3
3	Сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал	186.0
4	Ухуулах байрны түрээсийн зардал	3,405.0
5	Нэр дэвшигчээс зарцуулах хөлс, урамшууллын зардал	70,215.7
6	Нэр дэвшигчээс зарцуулах тээврийн хэрэгслийн зардал	12,792.2
7	Сонгуулийн сурталчилгаанд зарцуулах бусад зардал	10,069.5
8	Сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах зардал	6,056.0
9	Өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд материал нийтлүүлэх зардал	250.7
10	Цахим орчин дахь олон нийтийн сүлжээний цахим хуудаст шаардагдах зардал	808.8
11	Бусад зардал /аудитын төлбөр, хоол, хүнс, банкны шимтгэл/	10,184.9
		<b>ДҮН</b>
		<b>123,886.0</b>
<b>Ардчилсан нам</b>		
1	Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх зардал	3,824.7
2	Нийтийн эзэмшлийн гудамж талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар байршуулах зардал	1,477.3
3	Сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал	1,590.8
4	Ухуулах байрны түрээсийн зардал	3,100.0
5	Нэр дэвшигчээс зарцуулах хөлс, урамшууллын зардал	5,570.1
6	Нэр дэвшигчээс зарцуулах тээврийн хэрэгслийн зардал	13,237.5
7	Сонгуулийн сурталчилгаанд зарцуулах бусад зардал	1,014.2
8	Сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах зардал	300.0
9	Цахим орчин дахь олон нийтийн сүлжээний цахим хуудаст шаардагдах зардал	64.0
10	Бусад зардал /аудитын төлбөр, хоол, хүнс, банкны шимтгэл/	6,843.8
		<b>ДҮН</b>
		<b>37,022.3</b>
<b>Хүн нам</b>		
1	Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх зардал	<b>2,410.0</b>
2	Ухуулах байрны түрээсийн зардал	100.0
3	Нэр дэвшигчээс зарцуулах хөлс, урамшууллын зардал	13,717.0
4	Нэр дэвшигчээс зарцуулах тээврийн хэрэгслийн зардал	1,941.0
5	Сонгуулийн сурталчилгаанд зарцуулах бусад зардал	114.5
6	Сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах зардал	1,848.1

7	Цахим орчин дахь олон нийтийн сүлжээний цахим хуудаст шаардагдах зардал	1,000.0
8	Бусад зардал /аудитын төлбөр, хоол, хүнс, банкны шимтгэл/	17.4
<b>ДҮН</b>		<b>21,147.8</b>
<b>Иргэний хөдөлгөөн нам</b>		
1	Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх зардал	<b>1,000.0</b>
2	Сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал	149.0
3	Ухуулах байрны түрээсийн зардал	
4	Нэр дэвшигчээс зарцуулах хөлс, урамшууллын зардал	160.0
5	Нэр дэвшигчээс зарцуулах тээврийн хэрэгслийн зардал	1,030.0
6	Сонгуулийн сурталчилгаанд зарцуулах бусад зардал	9.1
7	Бусад зардал /аудитын төлбөр, хоол, хүнс, банкны шимтгэл/	13.9
<b>ДҮН</b>		<b>2,362.0</b>
<b>Нийт дүн</b>		<b>184,418.0</b>

**1.2.2 Нэр дэвшигч нар сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, ухуулагч нарын урамшуулал, шатахуун зэрэг зардлыг анхан шатны баримтгүй зарцуулсан байна.**

Орон нутгийн сонгуульд оролцсон 640 нэр дэвшигчдэд нийт 184,418.0 мянган төгрөгийн зардлыг зарцуулсан байна. Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх зардал, урамшуулал, тээврийн хэрэгслийн зардалд 16 нэр дэвшигч нийт 9,009.4 мянган төгрөгийг анхан шатны баримтгүй сонгуулийн зардлын данснаас зарцуулсан байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасан байхад дээрх нэр дэвшигчид зөрчсөн байна.

**Анхан шатны баримтгүй зарцуулсан зардлын хэмжээ**

Хүснэгт №8

/мянган төгрөг/

№	Нэр дэвшүүлсэн нам эвслийн нэр	Сумын нэр	Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах зардал	Нэр дэвшигчээс зарцуулах хөлс, урамшуулал, тээврийн хэрэгслийн зардал	Дүн
1	Монгол ардын нам	Сайншанд	-	450.0	450.0
		Замын-Үүд	100.0	-	100.0
		Мандах	-	185.0	185.0
		Өргөн	-	3,277.9	3,277.9
2	Ардчилсан нам	Сайншанд	-	100.0	100.0
		Замын-Үүд	140.0	200.0	200.0
3	Иргэний хөдөлгөөн нам	Хатанбулаг	1,000.0	1,190.0	2,190.0
<b>НИЙТ ДҮН</b>			<b>1,240.0</b>	<b>7,769.4</b>	<b>9,009.4</b>

Аймаг, сумын ИТХ-ын ээлжит сонгуульд оролцсон, зардлын тайлангаа ирүүлсэн нэр дэвшигчдээс иргэдтэй байгуулсан гэрээний дагуу холбогдох татварыг суутгаж, шилжүүлээгүй 14 нэр дэвшигч байна.

Дээрх нэр дэвшигчдээс хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1, 25.6-д заасан арга хэмжээг авч шийдвэрлүүлэх тухай саналыг аймгийн Татварын хэлтэст хүргүүллээ.

**1.2.3 Төрийн аудитын байгууллагаас тогтоосон зардлын дээд хэмжээг баримталж ажиллажээ.**

АНСДИТХСТ хуулийн 49.1 дэх заалтыг үндэслэн Төрийн аудитын байгууллагаас орон нутгийн сонгуульд нам, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоож, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн А/28 дугаар тушаалаар баталж, нийтэд мэдээлсэн.

Дээрх тушаалаар аймаг болон сумын ИТХ-ын сонгуульд зарцуулах зардлын хэмжээ болон сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчийн зарцуулсан зардлыг дараах хүснэгтэд тусгав.

*Нам, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын хэмжээ,*

*Хүснэгт №9*

*/сая төгрөг/*

№	Нэр	Аймгийн ИТХ		Сумын ИТХ		
		ТАГ-аас тогтоосон дээд хэмжээ	Зарцуулсан зардлын хэмжээний	ТАГ-аас тогтоосон дээд хэмжээ	Зарцуулсан хэмжээ	
1	Монгол ардын нам	366.0	44.1	16.0-36.0	-	
2	Ардчилсан нам	366.0	20.0	16.0-36.0	1,0-14.8	
3	Хүн нам	366.0	5,172.1	16.0-36.0	-	
4	Иргэний хөдөлгөөн нам	366.0	-	16.0-36.0	-	
5	Үнэн ба зөв нам	366.0	-	16.0-36.0	-	
6	Нэр дэвшигч	Монгол ардын нам	14.0-57.0	0.1-8.0	4.0-19.0	0.1-2.5
7		Ардчилсан нам	14.0-57.0	0.1-5.6	4.0-19.0	0.5-1.3
8		Хүн нам	14.0-57.0	1.0-9.5	4.0-19.0	-
9		Иргэний хөдөлгөөн нам	14.0-57.0	-	4.0-19.0	0.2-2.0
10		Үнэн ба зөв нам	14.0-57.0	-	4.0-19.0	-

Орон нутгийн ИТХ-ын ээлжит сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчид ТАГ-аас тогтоосон зардлын дээд хэмжээг баримтлан зориулалтын дагуу зарцуулсан байна.

## ДҮГНЭЛТ

Аймаг, сумын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланд хийсэн аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд:

1. АНСДИТХСТ хуулийн 56 дугаар зүйлийн 56.5-д заасны дагуу нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын дансны хуулгыг хуулийн хугацаанд харилцагч банкнууд бүрэн ирүүлсэн.
2. Орон нутгийн ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон намуудын сонгуулийн зардлын дансанд нийт 85,145.0 мянган төгрөг төвлөрч, 184,427.9 мянган төгрөгийг, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын дансанд 269,572.9 мянган төгрөгийг бүрдүүлж, 269,535.1 мянган төгрөгийн зардлыг сонгуулийн үйл ажиллагаанд зарцуулсан байна.
3. Сонгуулийн зардлын тайланг хянаж, дүгнэлт гаргасан хувийн аудитын 6 компани нь нэр дэвшигчдэд өгсөн мөнгөн болон мөнгөн бус хандивыг аудитын дүгнэлтэд үнэн зөв тусгаагүй байна.
4. Хандивын эх үүсвэр, хандив өгсөн иргэний нэр, регистрийн дугаар тодорхойгүй 131 иргэнээс өгсөн 21,182.5 мянган төгрөг, мөн 3 хуулийн этгээдээс өгсөн 4,000.0 мянган төгрөг, нийт 25,182.5 мянган төгрөгийг хууль, журмын дагуу буцаан төвлөрүүлэлгүй зарцуулсан байна.
5. Аймаг, сумын ИТХ-ын сонгуульд оролцсон 640 нэр дэвшигчээс 59 нэр дэвшигч мөнгөн бус хандивын гэрээг 260 иргэнтэй байгуулсан боловч хуульд заасны дагуу гэрээнд үнэлгээ тогтоогүй байна. Мөн 9 нэр дэвшигч мөнгөн бус хандивын гэрээ байгуулаагүй байна.
6. Нам, болон нэр дэвшигчид сонгуулийн зардлыг хуульд заасан шаардлага, зориулалтын дагуу, зардлын дээд хэмжээг баримтлан зарцуулсан байна.

**ХЯНАСАН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ

АУДИТОР:

Т.ГАН-ӨЛЗИЙ

АУДИТЫН МЕНЕЖЕР:

У.ОЮУНТҮЛХҮҮР



**АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭСЭН БАГИЙН ГИШҮҮД :**

АУДИТОР:

*Нас*

Н.МӨНХНАСАН

АУДИТОР:

*А. Дамчой*

А.ДАМЧОЙ

АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХАМТРАН ОРОЛЦСОНД  
ТАЛАРХАЛ ИЛЭРХИЙЛБЕ.

